

□
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

АРХИВЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Архивын аюулгүй ажиллагааны журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ журмыг мөрдөж ажиллахыг төрийн болон байгууллагын архивын дарга, эрхлэгч нарт, хэрэгжилтэд хяналт тавихыг Архивын ерөнхий газар /С.Энхбаатар/-д даалгасугай.

САЙД Х.НЯМБААТАР